

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2022/126/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Б.Уранбилэг Утас: 70523020 Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.08.24 № 1-Б/101

танай _____-ны № _____-т

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЗАМЫН-ҮҮД ДЭХ ГААЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ОТГОНСҮХ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	418.3	588.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	356.8	630.1
	Нийт хөрөнгийн дүн	775.1	1,219.0
	Нийт өр төлбөрийн дүн	6.3	42.5
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	768.8	1,176.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	775.1	1,219.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,288.0	3,415.9
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,984.3	3,052.5
	Үйл ажиллагааны үр дүн	303.7	363.4
	Үйл ажиллагааны бус үр дүн	0.0	0.0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	303.7	363.4
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	832.1	830.4
	Тайлант оны үр дүн	-63.3	363.4
	Эцсийн үлдэгдэл	768.8	1,176.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,180.7	3,179.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,177.2	3,162.6
	Үйл ажиллагааны ЦМГ	3.5	17.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-6.2	-16.3
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.0	0.0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	3.5	17.1
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2.9	0.2
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.2	1.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,834.5	1,804.8
	Урсгал зардал	1,834.5	1,804.8
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Улсын төсвөөс санхүүжих	1,828.1	2,009.9
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах, олон улсын хүний хорио болон мал амьтны Олон улсад шуурхай, тогтмол мэдээлэх халдварт өвчин, ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт

шавж, мэрэгч амьтан, хог ургамал улсын хилээр нэвтрэх, бусад урс оронд дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, импорт, экспортын бараа, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалт хийх чиг үүргийг гаалийн байгууллагад шилжүүлсэнтэй холбогдуулан Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 4-ний өдрийн тогтоолоор мэргэжлийн хяналтын байгууллагын албан хаагчид, эд хөрөнгө, байр зэргийг гаалийн байгууллагад шилжүүлж, бүтцийг өөрчлөн батлахаар тусгасан байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаандаа “EMERALD” программыг ашигладаг ба аудитын явцад хөрвүүлсэн журнал санхүүгийн тайлангаас зөрүүтэй, нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан гарахгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 34.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.0 сая төгрөгийн алдааг залруулж, 32.2 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

1. Тайлант хугацаанд ТӨБЗГ-ын 2021 оны А-1/1794 дугаар албан бичгээр 71.2 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасах зөвшөөрлийн дагуу хөрөнгийг зарлагадахдаа 1.7 сая төгрөгийн гарзыг бүртгээгүйгээс санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдсэн байна.
2. Тайлант хугацааны мөнгөн гүйлгээний журналаас түүвэрлэн авч үзэхэд 281.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг шууд зардлаар бүртгэсэн байна.

Албан шаардлага

1. Тайлант онд нийт 546.3 сая төгрөгийн үнэ төлбөргүй орлого хүлээн авч, бүртгэж, тайлагнасан байна. Үүнээс 170.4 сая төгрөгийн бараа материал, 375.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө авсан байна. Бараа материалыг ангилахад МХЕГ-аас 169.8 сая төгрөгийн БМ, 0.5 сая төгрөгийн алба хаагчдын буцаасан маягт байна. Үнэ

төлбөргүй хүлээн авсан орлогод 5.9 сая төгрөгийн хөрөнгийг БНХАУ-ын Замын-Үүд дэх Консулын газраас авсан байгаа дээд шатны байгууллагаас зөвшөөрөл аваагүй байна.

2. Тайлант хугацаанд 65.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа /авлага/, 42.5 сая төгрөгийн өглөгтэй байна. Авлага нь 2019 онд олгосон цалингийн урьдчилгаа байна. Харин өглөг нь Худалдаа хөгжлийн банктай "Үл хөдлөх эд хөрөнгө хөлслөх, ашиглах, эзэмших, худалдах, худалдан авах" гэрээний дагуу төлж байгаа Замын-Үүд сумд байрлах 0018127 гэрчилгээтэй, эрхийн улсын бүртгэлийн 0714000467 дугаартай, 176.11 м.кв талбайтай 2 давхар албан конторын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнийн үлдэгдэл төлбөр байгаа ба жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулсан байна. Харин тайлант хугацааны эцэст харилцагч байгууллагуудтай тооцоо нийлээгүй, өглөг, авлагыг баталгаажуулаагүй байна.
3. Мөнгөн гүйлгээний журналын ажил гүйлгээг эдийн засгийн ангиллаар шалгахад нийт 10.6 сая төгрөгийг эдийн засгийн ангилал зөрчиж, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.
4. Тус байгууллага 2021 онд 16.8 сая төгрөгийн мөнгөн кассаар авч зарцуулсан байна. Үүнээс 15.7 сая төгрөг нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.2-т "Төрийн байгууллага нь арилжааны банкны төлбөрийн картын дансанд байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бэлэн мөнгөний төрийн сангаас баталсан хязгаар /ЖМС/-ын дотор шилжүүлэн авч болох бөгөөд гадаад, дотоод томилолт, гадаад зочны зардал, тэтгэмж урамшуулал, шагналыг батлагдсан төсвийн хүрээнд шилжүүлэн авч болно" гэж заасныг зөрчиж бараа материал худалдан авах, төлбөр хураамж төлөх зэрэг зардлыг гарган, ажил гүйлгээ хийсэн байна. Мөн 2021 оны 12-р сард нийт 3.5 сая төгрөгийг бэлэн мөнгөөр авч зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 6.2-т заасан мөнгөн сангийн хэмжээг зөрчиж байна.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлоготой холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналын бүртгэлээс үзэхэд нийт 94 төрлийн 143 ширхэг 318.1 сая төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгө байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого,

зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасны дагуу тодорхой ажил зохион байгуулж, шийдвэрлэх.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	7	34.2	2	2.0			4	32.2	1	7
1	ТШЗ	7	34.2	2	2.0	0	0	4	32.2	1	7
	НИЙТ	7	34.2	2	2.0			4	32.2	1	7